

**Авлигын эсрэг зохион байгуулж буй соён гэгээрүүлэх  
үйл ажиллагааны ач холбогдол: хэрэгцээ шаардлага, хүчин зүйлс**

**Ойдовын Хатанболд \***

*Доктор (Ph.D)*

*Шинжлэх Ухааны Академийн*

*Философийн хүрээлэн*

*Улаанбаатар, Монгол Улс*

*khatanboldo@mas.ac.mn*

**Баднаагийн Ганцоож**

*Докторант*

*Удирдлагын Академийн Улс төр,*

*бодлого судлалын тэнхим*

*Улаанбаатар, Монгол Улс*

*gantsooj1028@gmail.com*

**Хураангуй**

Авлига нь улс орнуудын хууль дээдлэх ёс, ардчиллын институт, нийгмийн нэгдмэл байдал, эдийн засгийн хөгжлийг сулруулж, улс орны тогтвортой, аюулгүй байдалд ихээхэн аюул заналхийлж ирсэн тул 1990-ээд оноос олон улсын хамтын нийгэмлэгийн орнуудын засгийн газар хоорондын байгууллагуудаар дамжуулан олон улсын түвшинд авлигатай хийх тэмцлийг эрчимжүүлэх болсон. Бид энэхүү өгүүллээрээ авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлж буй дараахь үйл ажиллагаануудын талаарх иргэд, олон нийтийн санаа бодлыг тандаж, түүнд шинжилгээ хийхийг зорьсон. Ингэхдээ дараахь гурван зүйлд буюу (i) авлигын эсрэг хэрэгжүүлж буй мэдээлэл, сурталчилгааны өнөөгийн байдал, нөлөөлж буй хүчин зүйлсийг; (ii) авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй соён гэгээрүүлэх үйл ажиллагааны явцыг; (iii) авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны ач холбогдлыг үнэлж, бодит байдлыг тодруулахыг хичээв.

**Түлхүүр үгс:** *олон нийтмэй харилцах, соён гэгээрүүлэх, авлига, хэрэгцээ, сайн засаглал, иргэд*

**Importance of anti-corruption awareness raising activities: needs and factors**

**Khatanbold Oidov\***

*Doctor (Ph.D)*

*Institute of Philosophy,*

*Mongolian Academy of Sciences*

*Ulaanbaatar, Mongolia*

*khatanboldo@mas.ac.mn*

**Gantsooj Badnaa**

*Ph.D candidate student*

*Department of Political Science & Policy Studies,*

*National Academy of Governance*

*Ulaanbaatar, Mongolia*

*gantsooj1028@gmail.com*

**Abstract:**

Corruption weakens the rule of law, democratic institutions and social cohesion, hinders economic development, and exacerbates instability and security. Consequently,

\* The Corresponding author



© The Author(s) 2023

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

<https://orcid.org/0000-0001-7867-6850>

<https://orcid.org/0009-0006-4953-5366>

Received: 26 August 2023

Accepted: 27 September 2023

since the 1990s, the international struggle against corruption has been strengthened by intergovernmental organizations of countries in the International Community. The purpose of this article is to monitor and analyze the views of citizens and the general public on the activities of the Anti-Corruption Agency. The following three points should be taken into account: 1) the current situation and impact of information and information on the fight against corruption; 2) the progress of the activities of the anti-corruption awareness movement; and 3) the evaluation of the importance of the activities of the anti-corruption awareness movement and attempts to clarify the reality.

**Keywords:** *corruption, enlightenment, public awareness, public relations, good governance and citizens, demands*

## I. Оршил

Сайн засаглал, төрийн эх үүсвэрийг үр нөлөөтэй захиран зарцуулах, эрх мэдлийг зөв ашиглах, зөрчилдөөнийг зохицуулах тухай асуудал чухлаар тавигдсаар буй. Төрийн байгууллагуудын шударга байдал, түүнийг бэхжүүлэхийн төлөө засаглах эрхийг бодитой хянах бүх талын бололцоог хангах явдал болон хувирч байна. Энэ бол хариуцлагатай нийгэм, ёс суртахуунтай төр, иргэдийн оролцоотой хамтын зөвшилцөл, үнэн зөв, чөлөөт хэвлэл мэдээлэлтэй, шударга ёс давамгайлсан ардчилсан нийгэм байх ёстойг шаардаж байна. Энэ бол **авлигыг үл тэвчсэн**, шударга, тэгш оролцоотой, эрх тэгшийн зарчимд тулгуурласан тунгалаг нийгмийг цогцлоох суурь үндэс, бас гарваль болно. Учир нь ардчилал буруу хөгжсөнөөс энхийг сахиулах, аюулгүй байдлыг хамгаалах, нийтийн сайн сайхны төлөө ажиллах, эдийн засгийн өсөлтийг хангах зорилтоо хэрэгжүүлж чадахгүй байх явдал ч гардаг. Үүнийг доголдуулахад хүргэж буй томоохон сорилт, нөлөөлж буй хүчин зүйл нь авлига юм. Авлига бол ардчиллын чанар, үнэ цэнийг доройтуулдаг үзэгдэл учраас түүний нийгмийн амьдралд үзүүлж буй хор хөнөөлийг тодруулахыг оролдсон нь энэ өгүүллийн шинжлэх ухааны ач холбогдол орших болов уу.

Авлига нь улс орнуудын хууль дээдлэх ёс, ардчиллын институт, нийгмийн нэгдмэл байдлыг сулруулж, улмаар улс орны эдийн засаг, тогтвортой хөгжлийн чадавхад ноцтой аюул заналхийлдэг учраас 1990-ээд оноос олон улсын хамтын нийгэмлэгийн орнуудын засгийн газар хоорондын байгууллагуудаар дамжуулан олон улсын түвшинд авлигатай хийх тэмцлийг эрчимжүүлэх болсон. Үүний үр дүнд НҮБ-ын Авлигын эсрэг конвенцыг 2003 оны 10 дугаар сарын 31-ны НҮБ-ын Ерөнхий ассамблейн 58/4 тоот тогтоолоор баталж, мөн оны 12 дугаар сарын 9-ний өдөр Мексикийн Мерида хотноо гишүүн орнуудаар гарын үсэг зуруулж, улмаар конвенц 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн түүхтэй. Энэ цагаас хойш 2020 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн байдлаар дэлхийн 187 орон тус конвенцод нэгдэн орж, тэдгээр гишүүн орнуудаас Андора, Япон, Монако, Сан Марино зэрэг улсуудаас бусад 140 улс гарын үсэг зурж, соёрхон баталсан (UN. Signature and Ratification Status, 2023) байна. Монгол Улсын хувьд 2005 оны 4 дүгээр арын 29-ний өдөр гарын үсэг зурж, улмаар Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурал соёрхон баталсан (УИХ. Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон батлах тухай. 2005) байдаг. Тус конвенц нь үндсэн 4 хэсгээс бүрдэх бөгөөд

(i) төр, хувийн хэвшлийн салбар дахь урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгайлан заасан; (ii) авлигын болон авлигатай холбоотой олон янзын үйлдэл, зөрчлүүдийг тогтоохдоо улс оруудын мөрдөх шаардлагатай стандартуудыг тодорхойлсон; (iii) үндэстэн дамнасан авлигатай тэмцэх олон улсын хамтын ажиллагааг тусгасан; (iv) хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох асуудал авлигын эсрэг гэрээ, хэлэлцээрүүдийн тулгуур зарчим (UN. Signature and Ratification Status, 2023) зэргийг тус тус онцолсон. Үүнээс авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь зөвхөн шийтгэл хүлээлгэх арга хэмжээд төдийгүй нийгмийн амьдралд шударга ёсыг тогтоож, дэмжих цогц стратегид тулгуурлах ёстойг илтгэнэ. Шударга, мэргэшсэн байдлыг хангахад төрийн алба, удирдах албан тушаалтнуудын манлайллыг чиглүүлэгч зарчмын гүйцэтгэх үүргийг сахин биелүүлэх, шударга ёсны удирдлагын тогтолцоог бүрдүүлэн сахих (ЕАБХАБ, Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, 2016, 58, 59, 64) нь сайн засаглалыг хангах үйл ажиллагааны чухал зорилт болсоор байна.

Үнэн хэрэгтээ, авлигын эсрэг тэмцэл нь зөвхөн ёс суртахууны тэмцэл биш бөгөөд ёс суртахуун, шударга ёсны асуудал чухал болох дэлхийн гол шашин, нийгмийн үнэлэмжүүдийн хүрээнд хамгийн гол нь авлигаас үүдэлтэй ядуурал, зовлон, өлсгөлөн гачаал, баян хоосны ялгаа зэрэг бидний өмнө хамгийн хүнд сорилт болж буй нь энэ тэмцлийн гол утга учрыг тодорхойлж байна. Нэг үгээр авлигачдыг үзэн ядахаас илүү авлигын эсрэг тэмцлийг манлайлдаг идэвхтнүүд зориг эрмэлзлээр дүүрэн байж, шийдэмгий бөгөөд шийдэхийг байнга эрэлхийлэн идэвхтэй ажиллавал олон улсын болон үндэсний хэмжээнд уг асуудлыг анхаарлын Түвэд байлгах бүрэн боломж бий (Поуп. 2003, 4, 14) гэдгийг ямагт санаж байх хэрэгтэй. Энэхүү санамж нь олон түмний эрэлт хэрэгцээгээр бус ховдог шуналаар хөтлүүлэн цаашид шударга бус удирдлагыг лавшруулан хувийн салбарын хөгжлийн үндсийг нь тасалдуулбал авлига нь хүмүүний эрэлт хэрэгцээний нэгэн чухал тулгуур болох итгэл найдварыг тасчин хаях аюулын харангыг дэгдээх болно. Тэгэхээр авлига нь газар сайгүй байх аваас ужиг шинжтэй аюул болоод зогсохгүй зөвхөн улсын салбарын албан хаагчид өөрсдийн албан тушаалаа урвуулан ашиглах явдал төдий зүйл бус, хүмүүс мөнгө амар хялбар аргаар олох боломжтой газар бүрд өөрсдийн алба ажлаа урвуулан ашиглах байдлаар илрэх нь хамгийн хор хөнөөлтэй зүйл. Тиймээс түүнийг хянаж хязгаарлахгүйгээр ардчилсан институциуд, зах зээлийн эдийн засгийн амьдрах чадвар оршин тогтнохгүйгээс гадна аюултай эрсдэлд өртөнө.

Нэг үгээр авлигатай орчинд хөрөнгө нөөц нь ихэвчлэн ашиггүй салбар руу чиглэгдэж, улмаар хүчний байгууллагууд, нийгмийг хянаж дарангуйлах бүтцүүд бий болж, дарга нар өөрсдийгөө болоод эд хөрөнгө, эрх мэдлээ хамгаалахад (ЕАБХАБ, Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, 2016, 58, 59, 34) илүү анхаарал хандуулж эхэлнэ гэсэн үг. Ингэснээр нийгэмд үр ашигтай, өгөөжтэй байдлаас илүүтэй өөрт ашигтай, ач тусаа өгөх стандарт бус үйлдлүүд, аминч, хувиа хичээсэн зан суртахуун нийгэмд газар авч, улмаар ардчилсан байгууламжууд авлигад идэгдэж, засгийн газрын легитимт байдлыг хүлээн зөвшөөрөгдөх эрх нь алдагдана. Түүнээс гадна иргэдийн зүгээс төр, засагтаа итгэх итгэл асар хурдтай буурч, эргэлзэх зэрэг сөрөг хандлагууд бий болох эрсдэлтэй. Мөнхүү эрсдэлээс зайлсхийхийн тулд илүү ёс суртахуунтай, хүн бүр авлигын асуудлыг өөртөө өөрийнхөөрөө тавих буюу хүсэл эрмэлзэл, манлайлал нь дотроосоо төрөн гарч байх ёстой. Ингэж гэмээ нь

авлига хурдан устаад зогсохгүй түүнтэй тэмцэх тэмцлийг урт удаан хугацааны хичээл зүтгэлийг талаар болгохгүй бөлгөө. Нөгөө талаас, авлига бол ардчиллын чанар, үнэ цэнийг доройтуулдаг үзэгдэл. Энэ утгаараа өнөөдөр дэлхийн олон улсад Транспэрэнси интернэшнл байгууллагын Авлигын төсөөллийн индексийг хүлээн зөвшөөрөх хандлага нийтлэг болсон. Авлигын төсөөллийн индекс нь нэгдмэл аргачлал бүхий бие даасан судалгаа биш ч гэлээ АНУ, ХБНГУ, Их Британи, Швейцар, Гонконгод байрлан үйл ажиллагаа явуулдаг 13 байгууллагын судалгаа, үнэлгээний авлига болон түүнд холбогдох хэсгийн үзүүлэлтийг сонгон авч тодорхой аргачлалаар тооцдог индекс болно.

«Транспэрэнси интернэшнл» олон улсын төрийн бус байгууллагаас жил болгон боловсруулдаг улс орны төрийн албан дахь авлигын талаар шинжээч, бизнес эрхлэгчдийн төсөөлөлд үндэслэсэн Авлигын төсөөллийн индексийн 2021 оны дүнгээр Монгол Улс 35 оноо авч 180 улс орноос 110 дугаар байрт эрэмбэлэгдсэн (Transparency International 2023) байна. Нэг үгээр бол авлигын төсөөллийн индексээр дэлхийн улс орныг жагсаасан энэхүү жагсаалтад тухайн улс орны эзэлж буй байр бага зэрэг өөрчлөгдөх нь юуг ч илэрхийлэхгүй, учир нь жил бүр судалгаанд хамрагдах орны тоо өөрчлөгддөг. Гол нь индексийн агуулга хэрхэн өөрчлөгдөж буйд анхаарах нь чухал (О.Хатанболд, 2010, 114) Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хувьд сүүлийн 14 жилийн хугацаанд үнэлэгдсэн авлигын төсөөллийн индекс дунджаар 38-40 оноогоор үнэлэгдэж, улмаар дэлхийн улс орнуудын 110-115 байрт эрэмбэлэгдэж байна. Энэ нь тус судалгаанд оролцсон улс орнуудын гуравны хоёр нь 50-иас бага оноо авсан бөгөөд дунджаар 43 оноо буюу «илүү их авлигад автсан» гэсэн утгыг илэрхийлж байна (Зураг 1). Тэгвэл 2022 (Transparency International 2023) оны дүнгээр Монгол Улсын Авлигын төсөөллийн индекс өмнөх жилийнхтэй ижил 35 оноо авч 180 улсаас 110 дугаар байрт эрэмбэлэгдсэн бөгөөд 2020 оноос хойш эл оноо огт өөрчлөгдөөгүй гэж үзэж болохоор байна. Дээр өгүүлсэн олон улсын байгууллагын судалгаа, дүгнэлт болон Монгол Улсад тулгараад буй нөхцөл байдлыг харгалзан төрийн албан хаагчдын эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглаж буй байдлыг таслан зогсоох, бизнес эрхлэгчдэд учирч буй дарамт, хүнд суртал, авлигыг бууруулах төрийн байгууллагуудын ажлын уялдааг хангах зорилгоор Авлигын индексийг бууруулах үүрэг бүхий төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг байгуулан, төлөвлөгөө боловсруулж ажиллах нь зүйтэй гэж үзсэн байна.

Нөгөө талаар, манай улсад авлигын хэргийг шийддэг дагнасан шүүх тогтолцоог бүрдүүлэх шаардлага байгаа гэж үзжээ. Ийм чиглэлийн хэргийг дагнаж шийдэж байгаагүй шүүгч, өмгөөлөгч, прокурор, хуулийн байгууллагын ажилтнууд ажиллахаар хэрэг замхрах урьдач нөхцөл болсон хэмээн албаныхан үздэг. Энэ чиглэлийн хууль эрх зүйн орчин дутмаг байгааг Ерөнхий сайд онцолж, УИХ-ын Ёс зүйн хороотой хамтарч ажиллаж, ах, дүү, хамаатан, садны томилгоотой тэмцэхээ мэдэгдсэн юм. Төр тунгалаг байж чадвал хувийн хэвшлийнхэнтэй холбоотой авлигын асуудал үүсэхгүй гэдгийг Ерөнхий сайд онцолсон удаатай. Шинэ 30 жилд Монгол Улс авлигагүй болохын тулд хоёр жилийн хугацаанд нарийвчилсан ажлын төлөвлөгөө гаргах ажиллахаар болоод байна. Энэ хүрээнд 2021 оны 7 дугаар сард Монгол Улсын авлигын индексийг бууруулах ажлын хэсгийг Монгол Улсын засгийн газраас байгуулсан. Тодруулбал, “Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-

Эрдэнэ Авлигын индексийг бууруулах комиссыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар (Монгол Улсын Засгийн газар, 2021) хэлэлцэн баталсан. Засгийн газраас байгуулагдсан эл ажлын хэсэг нь авлигын хөшүүрэг болоод буй зарим төрлийн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, тодруулбал, 2021 оны наймдугаар сард багтан Засгийн газраас Шүгэл үлээгчийн тухай хуулийг боловсруулж, УИХ-д өргөн барих, түүнчлэн Улс төрийн намуудын тухай хуульд өөрчлөлт оруулж, намуудын санхүүжилтийг ил тод болгох, цаашлаад хамгийн их авлигад өртсөн байж болзошгүй салбар болох төрийн болон орон нутгийн өмчит компанийн эрх зүйн байдлыг тодорхой болгох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр (Б.Бадамгарав нийтлэлч), 2021) болсон байна.

Ажлын хэсгийн анхдугаар (2021.07.19) хуралдаанаар (i) *төрийн албан хаагчдын гаргаж буй хүнд суртал, чирэгдэл, авлига, шан харамж нэхээж буй тухай мэдээллийг 11-11 төвд иргэдээс байнга авч байх*; (ii) *E-Mongolia платформд авлигын асуудалтай холбоотой үэс гаргах*; (iii) *төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх салбар ажлын хэсэг байгуулан ажиллуулах*; (iv) *ажлын давхардал хийдлийг арилгах, иргэдэд учирч буй хүнд суртал, чирэгдлийн талаар байгууллага тус бүрээр нь үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг ажлуудыг авч хэрэгжүүлэх шийдвэрийг гарган үйл ажиллагаагаа (Б.Бадамгарав нийтлэлч), 2021) эхлүүлсэн.*

Энэ нь *нэг талаас*, Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, энэ үйл ажиллагаанд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх; *нөгөө талаас*, авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, ач холбогдлын талаарх олон нийтийн санаа бодлыг судлах хэрэгцээгээр тодорхойлогдсон гэж болно.

## **II. Судалгааны арга зүй**

Дээр дурдсан авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг тодруулах хүрээнд Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлж буй дараахь үйл ажиллагаануудын талаарх иргэд, олон нийтийн санаа бодлыг тандаж, түүнд шинжилгээ хийхийг энэхүү өгүүллээр зорив. Ингэхдээ судалгааны мэдээллийг урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу 2022 оны 4-5 сард цахим (*Google Forum*)-аар нийт 468 иргэдийг хамруулан цуглуулж, анхдагч мэдээллийг нийгмийн судалгааны тоон мэдээллийг боловсруулах IBM SPSS Statistics 23.0 багц программаар нэгтгэн, холбогдох шинжилгээг хийв. Тухайлбал, (i) авлигын эсрэг хэрэгжүүлж буй мэдээлэл, сурталчилгааны өнөөгийн байдал, нөлөөлж буй хүчин зүйлсийг; (ii) авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй соён гэгээрүүлэх үйл ажиллагааны явцыг; (iii) авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны ач холбогдолд үнэлгээ хийх явдал байв.

Түүнчлэн оршил хэсэгт тэмдэглэсэн «Транспаренси Интернэшнл» ОУ-ын төрийн бус байгууллагаас жил болгон боловсруулдаг улс орны төрийн албан дахь авлигын талаар шинжээч, бизнес эрхлэгчдийн төсөөллийн судалгааны арга зүйд

тулгуурласан судалгааны дүнд шинжлэх ухаан танин мэдэхүйн ерөнхий аргууд болох индукц ба дедукци, анализ ба синтез, харьцуулалтын аргуудыг ашиглан эл харьцуулсан шинжилгээг гүйцэтгэв. Харьцуулсан шинжилгээгээр авлигын нөхцөл байдал, хор уршиг, үр дагаврыг бууруулахад соён гэгээрүүлэх, олон нийтийн дунд авлигаас ангид байх сэдлийг бий болгоход чиглэсэн мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагаа, *Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн сувгуудын талаарх иргэд, олон нийтийн санаа бодлыг* ийнхүү чухалчилсан нь бидний судалгааны онол, арга зүйн үндэслэл болно.

### III. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн (2016-2022) 2.1.8-д *«иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх»* зорилтыг ил тод, нээлттэй байх буюу *«хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, иргэн, хуулийн этгээд хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлэх (3.1.3)»* зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ хэмээн заажээ. Энэхүү заалтыг үндэслэл болгон судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийн үр дүнг товч хураангуйлан толилуулж байна.

Тодруулбал, судалгаанд оролцогчдыг насны ангиллаар авч үзвэл, 4 хувь нь 20 хүртэлх насныхан, 29.3 хувь нь 21-30 насныхан, 41.6 хувь нь 31-40 насныхан, 16.8 хувь нь 41-50 насныхан, 6.3 хувь 51-60 насныхан, 2 хувь 61-ээс дээш насныхан байв. Нэг үгээр, судалгаанд оролцогчдын 90 гаруй хувь нь 21-60 насныхан байгаа нь нийгэм, эдийн засгийн идэвхтэй насны хүн амын зохих төлөөлөл түлхүү хамрагдсан. Үүнийг хамрагдсан иргэдийн тоо, оршин суугаа газар, хүйс, боловсрол болон хөдөлмөр эрхлэлт зэргээр тодруулсныг доорх зургаас дэлгэрүүлэн харах боломжтой.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо, оршин суугаа газар, хөдөлмөр эрхлэлт, хүйс, боловсрол

хамрагдсан иргэд - 468		хүйс		боловсрол		хөдөлмөр эрхлэлт	
орон нутаг	18.6%	эрэгтэй	38.4%	дээд	88.9%	төрийн албан хаагч	39.6%
нийслэл	73.9%			бүрэн дунд	8.4%	хувиараа хөдөлмөр эрхлэгч	14.7%
гадаадад оршин суугчид	0.7%	эмэгтэй	61.6%	тусгай дунд	2.0%	ажил олгогч	2.0%
				суурь боловсрол	0.7%	өндөр настан	3.8%
						оюутан	9.8%
						бусад чиглэлээр хөдөлмөр эрхлэгчид	30.1%

Нэмж хэлэхэд, судалгаанд хамрагдсан иргэдийн 6.8 хувь нь өөрийн оршин суугаа газрыг асуусан асуултад бүрэн хариулт өгөхөөс татгалзсан болохыг энд дурдах нь зүйтэй.



Монгол Улс дахь авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл иргэдэд ихэвчлэн мэдээллийн ямар эх сурвалжуудаар хүрч, авлигын эсрэг хэрэгжүүлж буй мэдээлэл, сурталчилгааны талаар иргэд хэр зэрэг мэдэж байгааг тодорхойлох үүднээс олон нийтийн дунд цахимаар явуулсан судалгааны голлох үр дүнг дээр дурдсан гурван багц асуудлын хүрээнд дараахь байдлаар танилцуулж байна.

(i) *Авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар мэдээлэл авч буй байдалд хийсэн шинжилгээ*: Бидний судалгаанд хамрагдсан 3 иргэн тутмын нэг нь буюу 38.8 хувь нь авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэрэгцээтэй үедээ авч чаддаг, харин 3 иргэн тутмын хоёр нь (61.2 хувь) энэ чиглэлийн мэдээллийг хэрэгцээтэй үедээ авч чаддаггүй ажээ. Тухайлбал, дээрх асуултад хариулсан байдлыг судалгаанд оролцогчдын насаар ангилан үзвэл 20 хүртэлх насныхны 22.2 хувь, 21-30 насныхны 26.2 хувь, 31-40 насныхны 41,3 хувь, 41-50 насныхны 49,3 хувь, 51-60 хүртэлх насныхны 59.3 хувь, 61-ээс дээш насныхны 77.8 хувь нь хэрэгцээтэй үедээ мэдээлэл авч чаддаг байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцогчдын нас нэмэгдэх тусам хэрэгцээтэй үедээ авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх мэдээлэл олж авах боломж нэмэгддэг болох нь ажиглагдав. Харин авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг авч чаддаггүй шалтгааныг тодруулахад дараахь байдал ажиглагдсан юм (Зураг 2).

Зураг 2. Мэдээллийг авч чадахгүй байгаа шалгаан (хувиар)



Үүнээс АТГ-ын соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа тухайн байгууллагын төвшинд тодорхой үе шат, төлөвлөгөөтэйгөөр явагддаг ч гэлээ, тэрхүү үйл ажиллагаа нь иргэдийн өдөр тутмын бодит амьдралд төдийлөн үр өгөөжээ өгөхгүй байх явдал байна хэмээн үзэв. Түүнээс гадна, энэ чиглэлээр олон арван арга хэмжээ авч хэрэгжүүлдэг ч иргэдийн ухамсар, улс төрийн соёл, авлигаас ангид байх соёлын төлөвшил хангалтгүй байгаа нь үүнд бас нөлөөлж буй хэмээн үзэж болох талтай. Учир нь судалгаанд оролцсон иргэдийн дунд авлигын талаарх мэдээллийн хэрэгцээ гардаггүй эсхүл хэрэгцээтэй мэдээлэл байдаггүй гэж үзэх хандлага нийтлэг байгаа нь үүнийг гэрчилнэ.


Дурдсан нөхцөлийг тодруулах зорилгоор нэмэлт тайлбар хийх байдлаар оролцогчдоос авлигын талаарх мэдээллийг авч буй гол эх сурвалжуудыг тодруулахыг оролдов. Чингэхэд иргэд, олон нийт энэ чиглэлийн мэдээллийг телевиз, олон нийтийн сүлжээ, төрийн байгууллага, мэргэжилтнүүдээс түлхүү авч байгаа нь судалгааны үр дүнгээс тодорхой харагдсан. Тодруулбал, асуулгын судалгаанд оролцсон нийт 468 иргэнээс авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй гол эх сурвалжуудаа тодорхойлсон 839

сонголт (давтагдсан тоогоор) бүртгэгдсэнээс тэдний 27.3 (229) хувь нь телевизээс, 28.1 (236) хувь нь олон нийтийн сүлжээ (Facebook, Twitter)-ээс, 15.9 (133) хувь нь төрийн байгууллага, мэргэжилтнүүдээс мэдээлэл авч, тэдгээрийг өөрсдийн баталгаатай эх сурвалж хэмээн үзэж буйгаа илэрхийлсэн байна. Үүнээс иргэдийн дунд авлигын эсрэг хэрэгжүүлж буй мэдээлэл, сурталчилгааг хэр зэрэг мэддэг талаар тодруулах нь чухал хэмээн үзэж нарийвчлан шинжилгээ хийж үзэв. Нийт судалгаанд оролцогчдын 60 гаруй хувь нь телевизийн нэвтрүүлэг, видео болон радио контентын талаар, 50 орчим хувь нь гудамжны сурталчилгааны самбар, дэлгэцийн сурталчилгаа, мэдээллийн самбар, нийтлэлийн талаар, 40 орчим хувь нь зурагт хуудас, нугалбар, тараах материал, үзүүлэн, таниулах хуудас, нийтийн тээврийн сурталчилгааны талаар “мэднэ” гэж хариулжээ. Харин оролцогчдын 3 хүн тутмын нэг нь буюу 30 гаруй хувь нь авлигын эсрэг хэрэгжүүлж буй мэдээлэл, сурталчилгааг сургалт, семинар, видео болон цахим хичээл, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, цахилгаан шат, ханын сурталчилгаануудаас илүүтэй олж мэддэг төдийгүй түүнийг бодит эх сурвалж болж буйг илтгэнэ.

Иргэд хэдийгээр авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар мэдээлэл авч болох эх сурвалжууд, энэ төрлийн зорилтот өдөрлөг, нийтийг хамарсан арга хэмжээ, орон нутаг дахь сурталчилгаа зэргийг “сайн мэдэхгүй” байх нь харилцан адилгүй байна. Үнэндээ иргэд, олон нийт энэ төрлийн үйл ажиллагаанд оролцож авлигын эсрэг тэмцэх аливаа арга хэмжээнд оролцож, үзэл бодол, дуу хоолойгоо илэрхийлэх явдал иргэдийн нийгмийн өмнө хүлээсэн чухал үүрэг хэмээн ухамсарлах зүйн.

Дээрх шалтгааныг үндэслэл болгон судалгаанд оролцогчдоос тэдний хувь хүний нийгмийн хариуцлагыг тодруулах үүднээс тодорхой кэйсээр тодруулга авч үзэхэд дараахь байр суурь нийтлэг ажиглагдсан юм.

Зураг 3. Авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгаа дахь оролцоо (хувиар)



Үүнээс харвал, судалгаанд оролцогчид бүгд авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгааны талаарх мэдээллийг авч байсан хэдий ч түүнээс 10.8 хувь нь тухайн үйл ажиллагаанд оролцож байжээ. Мөн судалгаанд оролцогчдын 10 хүн тутмын нэг нь эл мэдээллийг аваад оролцож буй, аль эсвэл мэдээлэл авсан хэдий ч оролцож байгаагүй хэмээн иргэдийн 3 хүн тутмын нэг нь хариулсан байна. Үүнээс улбаалан, тухайн дурдсан асуудлыг судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсээр харьцуулан үзэхүл, мэдээлэл авч байсан хүмүүсийн 43.6 хувь нь 30-40 насныхан байгаа бол, мэдээлэл аваад оролцож байсан хүмүүсийн 72.5 хувь нь 30-50 насныхан байна. Хүйсийн хувьд, эрэгтэйчүүдийн 55.7 хувь, эмэгтэйчүүдийн 48.9 хувь нь



мэдээлэл авч байсан, харин эрэгтэйчүүдийн 8.4 хувь, эмэгтэйчүүдийн 11.7 хувь нь мэдээлэл аваад оролцож байсан гэж хариулсан нь авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгаа дахь оролцоо зарим талаараа төлөөлөл хангахуйц боловч үүнийг илүү үр дүнтэй нийгмийн өндөр хариуцлагатай, ёс суртахуунтай болгон төлөвшүүлэхэд тусгайлан анхаарч ажиллах шаардлага улам бүр нэмэгдсэнийг илтгэж байна.


Тэгвэл, судалгаанд оролцогчид Авлигатай тэмцэх газрын олон нийттэй харилцах үйл ажиллагааны үр дүнг хэрхэн үнэлж байгаа талаар товч авч үзье.

Олон нийттэй харилцах чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүнг судалгаанд оролцогчдын 44.6 хувь нь «хангалтгүй», 31.3 хувь нь «дунд зэрэг» гэж үнэлжээ. Мөн тэдний 16.1 хувь нь энэ үйл ажиллагааг үнэлж «мэдэхгүй» байгаагаа илэрхийлсэн. Харин нийт судалгаанд оролцогчдын 8.1 хувь нь дээрх үйл ажиллагааг «сайн», «маш сайн» гэж үнэлснээс дундаж үнэлгээг тооцон гаргавал 2.13 болов. Энэ нь энэ төрлийн үйл ажиллагаа төдийлөн хангалттай бус байгааг харуулж байна хэмээн үзэхэд хүргэв.

(ii) *Соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ*: Өгүүллийн энэ хэсэгт АТГ-аас иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүний ач холбогдлыг иргэд, олон нийт хэрхэн ойлгож, үнэлснийг танилцуулахыг зорьсон юм. Ингэхдээ дурдсан асуудлаар ямар бүлэгт хамгийн их хэрэгцээтэй, нэн тэргүүнд зохион байгуулах шаардлагатай ямар үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх, цаашдаа тухайн арга хэмжээг сайжруулах талаар ямар санал, бодолтой байгааг тодруулахыг хичээсэн гэж болно.


Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд мэдээллийн ямар сувгаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэх нь илүү үр дүнтэй байгаа талаарх судалгаанд оролцогчид нэг бус удаа онцолсон байна. Үүнийг илүү нарийвчлан тодруулж, гарсан үр дүнг дараахь байдлаар танилцуулж байна. Тухайлбал, авлигын эсрэг хууль, тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах чиглэлээр явуулж буй арга хэмжээ нь иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх нэн чухал хэсэг болсныг харуулав. Үүний нэг жишээ бол, тус улсад авлигын эсрэг хэрэгжиж буй хууль, тогтоомжийг олон нийтэд сурталчлах үйл ажиллагааны ач холбогдол ямар төвшинд буйг үнэлүүлэхэд «дунд» болон «дундаас доогуур» гэж үнэлэх хандлага өндөр байв (Зураг 4). Тухайлбал, оролцогчдын 37.6 хувь нь «дунд зэрэг» гэж үнэлсэн бол, 48.4 хувь «муу» болон «маш муу» гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд үүнээс дундаж үнэлгээг тооцон гаргахад 2.46 байна.

*Зураг 4. Хууль, тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах, хүргэх үйл ажиллагааны ач холбогдлын талаарх судалгаанд оролцогчдын үнэлгээ (хувиар)*



Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагатай авлигаас ангид байх соён гэгээрүүлэх үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажиллаж буй хэлбэрийг судалгаанд оролцогчдоор үнэлүүлэхэд 16.8-20.4 хувь нь «муу», 34.1-36 хувь нь «дунд зэрэг», 4.9-10.1 хувь «сайн», 1-3 хүртэлх хувь «маш сайн» гэж үзсэн. Эл үнэлгээг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагаар нь харьцуулбал: авлигатай тэмцэх чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллаж буй байдлыг дунд болон дундаас дээгүүр үнэлэх хандлага нийтлэг байна. Харин хувийн хэвшилтэй хамтран ажиллаж буй байдлыг «муу» гэж үнэлсэн нь төр, иргэний нийгмийн байгууллагатай хамтрах байдлаас өндрөөр үнэлэгдсэн нь ажиглагдлаа.

Зураг 5. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллаж буй үйл ажиллагааны ач холбогдлын талаарх үнэлгээ (хувиар)



Дээрх зурагт харуулсан харьцуулалтаар төрийн байгууллагатай хамтран ажиллаж буй байдлын дундаж үнэлгээг тооцвол: хувийн хэвшилээс 0.22 пунктээр, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллаж буй байдлын үнэлгээнээс 0.15 пунктээр тус тус өндөр байна. Энэ нь төрийн зүгээс хувийн хэвшилтэй хамтран ажиллах - 2.2, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах - 2.29-оор тус тус үнэлэгдсэн нь дунджаас доогуур үнэлэгдсэн болохыг харуулна. Харин авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа явуулах үйл ажиллагааны ач холбогдлыг судалгаанд оролцогчдын 50.9 хувь нь «муу», 35.1 нь «дунд зэрэг», 10.4 хувь нь «сайн»-аар, 3.6 хувь нь энэ чиглэлээр үнэлгээ өгч «чадахгүй» гэжээ. Ийнхүү үнэлсэн нь тус үйл ажиллагааны дундаж үнэлгээ 2.42 гарахад хүрсэн гэж дүгнэж болно. Энэ нь авлигатай тэмцэх чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрхэн ойлгож байгааг тодруулах алхам болов. Тодруулбал, оролцогчдын 52 хувь нь соён гэгээрүүлэх үйл ажиллагааг авлигыг үл тэвчих хандлага, дадал, соёл төлөвшүүлэх хэмээн ойлгож буйн илэрхийлэл мөн. Авлигын эсрэг сургалт, семинар зохион байгуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, судалгаа, үнэлгээ хийх үйл ажиллагаа өнөөдөр чухал ач холбогдолтой хэвээр байгааг давхар илтгэж буй хэрэг. Үнэндээ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн тэргүүн зорилтуудын нэг нь «шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн

*нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх, мөн шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх»* (УИХ, АТГ 2016) явдал хэмээн заасныг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Эл заалтын хэрэгжилт бодит амьдралд хэрхэн биеллээ олж буй тодруулахаар авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулж буй сургалт, семинар, мэргэжил арга зүйн дэмжлэг, судалгаа, үнэлгээ хийх үйл ажиллагааны ач холбогдлыг судалгаанд оролцогчдоор үнэлүүлэв. Ингэхэд авлигын эсрэг сургалт, семинар зохион байгуулах үйл ажиллагааны дундаж үнэлгээ 2.46, авлигыг бууруулах чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны дундаж үнэлгээ 2.32-аар, судалгаа, үнэлгээ хийх үйл ажиллагааны дундаж үнэлгээ 2.36-аар үнэлсэн байна. Эдгээр үйл ажиллагааны ач холбогдлыг 1-5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд түүний дундаж болох 2.5 руу дөхсөн үзүүлэлттэй байв.

Харин иргэд, олон нийтийг хамарсан нээлттэй арга хэмжээ зохион байгуулах үйл ажиллагааны ач холбогдлын талаар тухайлбал, АТҮХ-хөтөлбөрийн зорилгод тусгагдсан *«...авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх»* чиглэлийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагааг судалгаагаар тодрууллаа. Ингэхэд, авлигатай тэмцэхэд иргэд, олон нийтийг хамарсан нээлттэй арга хэмжээ зохион байгуулах үйл ажиллагааны ач холбогдлыг судалгаанд оролцогчдын 19.1 хувь *«маш муу»*, 36 хувь нь *«муу»*, муу, 28.1 хувь нь *«дунд зэрэг»*, 9.7 хувь нь *«сайн»*, сайн болон *«маш сайн»*, харин 7.2 хувь нь дээрх үйл ажиллагааны ач холбогдлыг үнэлж *«мэдэхгүй»* буйгаа илэрхийлжээ. Үүнээс дундаж үнэлгээг тооцвол 2.32 гарав. Энэ нь судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь авлигатай тэмцэх чиглэлээр иргэд, олон нийтийг хамарсан нээлттэй арга хэмжээ зохион байгуулах үйл ажиллагааны ач холбогдлыг *«муу»* хэмээн үзэж буйг илтгэсэн нь анхаарал татах асуудал болж байна.

Үнэлгээ ийнхүү сөрөг гарсан нь зарим талаар иргэд, олон нийтийг хамарсан нээлттэй арга хэмжээ зохион байгуулах өдөр ирэх тусам үлэмж нэмэгдэж буй цахим хэрэглээний тэлэлтийг тооцон үзэхийг чухалчилж байна. Тодруулбал цахим контент, шторк, баннер боловсруулах, тараах үйл ажиллагааг өрнүүлэх, түүний ач холбогдлыг нэмэгдүүлэх хэрэгтэйг илтгэж байна. Нөгөөтгээгүүр судалгаанд оролцогчдын 41.2 хувь нь *«маш муу»*, 32.6 хувь нь *«дунд зэрэг»*, 20.7 хувь нь *«сайн»*, *«маш сайн»* гэж үнэлсэн бол, 5.6 хувь нь дээрх үйл ажиллагааг үнэлж *«мэдэхгүй»* байгаа нь судалгаагаар илэрсэн юм. Тодруулбал, 5 хүн тутмын хоёр нь *«муу»*, 3 хүн тутмын нэг нь *«дунд зэрэг»*, 5 хүн тутмын нэг нь цахим контент, шторк, баннер боловсруулах, тараах үйл ажиллагааг өрнүүлэх, түүний ач холбогдлыг *«сайн»* гэж үзсэн байна. Эндээс дундаж үнэлгээг тооцвол 2.68 буюу дунджаас *«ялимгүй»* дээгүүр үнэлэгдэж байна.

(iii) *Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны ач холбогдлын талаарх нэгдсэн үнэлгээ:* Авлигатай тэмцэх чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагааны ач холбогдлыг хэрэгжүүлж буй 10 төрлийн үйл ажиллагаагаар нь судалгаанд

оролцогчдоор үнэлүүлэхэд дараахь сонирхолтой дүр зураг ажиглагдсан. Тухайлбал, судалгаанд оролцогчид дор дурдсан арван төрлийн үйл ажиллагааг ач холбогдлоор нь (1-5 хүртэлх оноо) үнэлүүлэхэд тэдний үнэлгээ **2.2-2.68** хооронд хэлбэлзэж, үнэлгээний **дундаж 2.4** голчтой гарав. Тодруулбал, цахим контент, шторк, баннер боловсруулах, түгээх (2.68), авлигын эсрэг хууль, тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах, хүргэх (2.46), авлигын эсрэг сургалт, семинар зохион байгуулах (2.46) зэрэг багтсан. Түүнээс гадна авлигатай тэмцэх чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах (2.44), авлигыг үл тэвчих үзэл төлөвшүүлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа явуулах (2.42) үйл ажиллагааны ач холбогдлын талаарх үнэлгээ бусад үйл ажиллагааны үнэлгээнээс ялимгүй өндрөөр үнэлэгдсэн.

Тэгвэл, авлигатай тэмцэх чиглэлээр хувийн хэвшил (2.2), иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах (2.29), иргэд, олон нийтийг хамарсан нээлттэй үйл ажиллагаа зохион байгуулах (2.32), авлигыг бууруулах чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх (2.32) зэрэг үйл ажиллагааны ач холбогдлын талаарх үнэлгээний дундаж нь бусад төрлийн үйл ажиллагааны үнэлгээнээс ялимгүй доогуур буюу голч үнэлгээнээс 0.04 – 0.2 пунктээр бага байна. Үүнээс үйл ажиллагаа тус бүрийн үнэлгээний дунджийг тооцвол, ерөнхий үнэлгээ *«дунд зэрэг»* (үнэлгээний дундаж 2.4)-ээр үнэлэгдсэн нь дурдсан үйл ажиллагаа хоорондын үнэлгээний зөрүү маш бага байгааг харуулсан гэж болно.

Ийнхүү авлигатай тэмцэх чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагаа өнөөгийн нийгмийн бүлгүүдийн хэрэгцээг хэрхэн хангаж буй болон тэдгээрт чиглэсэн үйл ажиллагааг тухайлан авч үзэхийг өгүүллийн энэ хэсэгт хөндөв. Тодруулбал, нийгмийн тодорхой бүлгүүдэд чиглэсэн авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгцээ, шаардлага өсөн нэмэгдэж байгаа талаар салбарын судлаачид, экспертүүд болон энэ салбарт ажиллагсад онцгой ач холбогдол өгч өргөн хүрээнд хэлэлцэх боллоо. Энэ нь нэг талаар хязгаарлагдмал хүрээнд яригдаж буй мэт боловч нийгмийн харилцааны өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой зорилго тавьж ажиллаж буй нийгмийн хариуцлага, шударга, ёс зүйтэй нийгмийг төлөвшүүлэхэд нийгмийн давхраа, бүлэг тус бүрийн үүрэг болохыг бэлхнээ харуулсан (Хүснэгт 1).

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд ч энэ асуудлаар тодорхой зорилт *«улс төрийн нам болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах»*-ыг дэвшүүлэн олон талт үйл ажиллагааг бодлогын түвшинд хэрэгжүүлсээр ирснийг дурдах нь зүйтэй.

Хүснэгт 1. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны ач холбогдлын талаарх үнэлгээ (хувь)

№	Үйл ажиллагаа	Маш муу	Муу	Дунд зэрг	Сайн	Маш сайн	Мэдэхгүй	Нийт
1	Авлигын эсрэг хууль, тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах, хүргэх	16.8	31.6	37.6	9.7	1.3	2.9	100.0
2	Авлигыг үл тэвчих үзэл төлөвшүүлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа явуулах	17.6	33.3	35.1	8.4	2.0	3.6	100.0
3	Авлигын эсрэг сургалт, семинар зохион байгуулах	16.0	33.6	29.3	10.4	2.7	8.0	100.0
4	Авлигыг бууруулах чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх	18.5	37.4	27.6	6.0	2.7	7.8	100.0
5	Авлигыг бууруулах чиглэлээр судалгаа, үнэлгээ хийх	17.3	35.5	27.7	8.0	2.0	9.5	100.0
6	Авлигатай тэмцэх чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах	16.8	34.1	28.3	10.1	2.9	7.8	100.0
7	Авлигатай тэмцэх чиглэлээр хувийн хэвшилтэй хамтран ажиллах	20.4	36.0	25.2	4.9	0.9	12.6	100.0
8	Авлигатай тэмцэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах	19.2	33.9	26.6	7.2	1.4	11.7	100.0
9	Иргэд, олон нийтийг хамарсан нээлттэй үйл ажиллагааг зохион байгуулах	19.1	36.0	28.1	7.9	1.8	7.2	100.0
10	Цахим контент, шторк, баннер боловсруулах, тараах	14.2	27.0	32.6	16.0	4.7	5.6	100.0

Нэг үгээр, бодлогын зорилт, түүнийг хангах чиглэлээр болон үйл ажиллагааны үр дүн, нийгэмд үзүүлж буй үр нөлөө, үйл ажиллагаагаар нь иргэд, олон нийтийн ойлголт, төсөөллийг тандах, хэрэгцээг тодорхойлох явдал эдүгээ хурцаар тавигдаж байна. Чухам иймээс авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа нийгмийн ямар бүлэгт түлхүү хэрэгцээтэй байгааг судалгаанд оролцогчдоор үнэлүүлж бодит дүр зургийг гаргахыг бид хичээсэн юм. Ингэхдээ бүлэг тус бүрийн хэрэгцээг үнэлсэн үнэлгээний дунджийг тооцон, харьцуулалт хийхэд дараахь нөхцөл байдал ажиглагдсан болно (Хүснэгт 2).


Хүснэгт 2. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хэрэгцээ (бүлэг, хувиар)

№	Бүлэг	Маш бага	Бага	Дунд зэрг	Их	Маш их	Мэдэхгүй	Нийт
1	Хүүхэд багачууд	16.2	19.9	22.2	23.1	15.0	3.7	100.0
2	Оюутан, залуус	5.9	10.0	20.0	33.9	28.5	1.6	100.0
3	Ахмадууд	9.3	17.1	33.3	22.5	13.4	4.4	100.0
4	Өндөр орлоготой иргэд	4.5	5.9	13.8	36.0	36.7	3.2	100.0
5	Улс төрийн намын гишүүд дэмжигчид	5.4	2.7	8.7	28.9	51.9	2.5	100.0
6	Хувийн хэвшлийн удирдлага, ажиллагсад	4.3	5.2	14.9	36.2	37.3	2.0	100.0
7	Шүүхийн салбарт ажиллагсад	5.2	4.3	7.2	26.9	52.7	3.8	100.0
8	Хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсад	3.4	5.7	11.6	30.4	44.7	4.3	100.0
9	Төрийн өндөр албан тушаалтнууд	4.6	3.3	8.8	26.8	52.2	4.2	100.0
10	Төрийн албан хаагчид (дунд, доод шатны)	4.2	5.1	12.0	29.3	44.2	5.1	100.0
11	Бусад	5.8	7.8	17.4	23.0	25.6	20.3	100.0

Судалгааны үр дүнгээс авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хамгийн их хэрэгцээтэй байгаа бүлгүүдэд улс төрийн намын гишүүд дэмжигчид, шүүхийн салбарт ажиллагсад, төрийн өндөр албан тушаалтнууд болох нь ажиглагдсан. Дээрх

шалтгаан нөхцөлд тулгуурлан бүлгүүдийн дундаж үнэлгээг тооцвол, дурдсан бүх бүлгүүдийн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хэрэгцээ **3.1-4.24** онооны хооронд үнэлэгдсэн нь нийгмийн эдгээр бүлгүүдэд бодит хэрэгцээ харьцангуй өндөр байгаа нь нотлогдсон хэмээн үзэх боломжтой (Зураг 6).

Зураг 6. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хамгийн их хэрэгцээ буй нийгмийн бүлгүүдийн үнэлгээний дундаж



Тайлбар: Дундаж үзүүлэлт (5-маш сайн, 4-сайн, 3- дунд зэрэг, 2-муу, 1-маш муу)

Дээрх нийгмийн бүлгүүдийн хэрэгцээг үнэлж гаргасан дундаж үнэлгээнд тулгуурлан бүлгүүдийн авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хэрэгцээг дараахь гурван түвшинд ангилж болохоор байна. *Нэгдүгээрт*, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хамгийн өндөр түвшний хэрэгцээтэй байгаа бүлэгт: төрийн өндөр албан тушаалтнууд, шүүхийн салбарт ажиллагсад, улс төрийн намын гишүүд, хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсад, төрийн албан хаагчид (*дунд, доод шатны*)-ын бүлгүүдийг хамааруулсан. Эдгээр бүлгүүдийн хэрэгцээний дундаж үнэлгээ 4.1-4.24 буюу *«маш их»* хэрэгцээтэй нь илэрсэн. *Хоёрдугаарт*, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа *«их»* хэрэгцээтэй буюу дундаж үнэлгээгээр 3.5-4.0 хүртэлх оноогоор үнэлэгдэж байгаа бүлгүүдийг энэ түвшинд хамруулахад, хувийн хэвшлийн удирдлага, ажиллагсад, өндөр орлоготой иргэд, оюутан, залуучуудыг бүлэг нийтлэг багтсан юм. *Гуравдугаарт*, *«дундажаас дээгүүр хэрэгцээтэй»* гэж хэлж болох бүлгүүдэд ахмад болон өвсөр насныханы багтсан бөгөөд үнэлгээгээр 3.01-3.5 хооронд үнэлэгдсэнээс ийнхүү үзэж болохоор байна.

Үүнээс авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны ерөнхий үнэлгээг нэгтгэн гаргавал, эл судалгаанд оролцогчдын ерөнхий үнэлгээгээр тэдний 12 хувь энэ талаар *«хэлж мэдэхгүй»*, 42 хувь *«хангалтгүй»*, 37 хувь *«дунд зэрэг»*, 9 хувь *«сайн, маш сайн»* гэж үнэлсэн байна. Үүнээс авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүнгийн талаарх судалгааны ерөнхий үнэлгээний дундажыг тооцвол **2.05** оноо гарсан нь судалгаанд оролцогчид дундаас доогуур үнэлэх хандлагатай байгаа нь харагдсан. Үнэлгээний давтамж, хувийг тооцож үзвэл:



Хүснэгт 3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ (давтамж, хувиар)

үнэлгээ	хангалтгүй	дунд зэрэг	сайн	маш сайн	мэдэхгүй	хариулаагүй	нийт
тоо	190	168	38	6	54	12	468
хувь	40.6	35.9	8.1	1.3	11.5	2.6	100

Дээрх үр дүнгээс үзэхэд, авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг судалгаанд оролцогчдын 40.6 хувь «хангалтгүй», 35.9 хувь «дунд зэрэг», 9.4 хувь «сайн, маш сайн», 11.5 хувь нь «үнэлж мэдэхгүй» байна гэсэн үнэлгээг өгчээ. Тэгвэл, судалгаанд оролцогчдоор авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг шалгах, авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, соён гэгээрүүлэх, судалгаа шинжилгээ хийх, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах зэрэг үйл ажиллагааны ач холбогдлыг үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 3.74-3.85 хооронд хэлбэлзэв. Бусад үйл ажиллагааны ач холбогдлуудын үнэлгээ дунджаар 3.78 голчтой гарав (Зураг 7).

Зураг 7. Авлигатай тэмцэх үйл ажиллагааны ач холбогдол (үнэлгээний дундаж)



Дурдсан нөхцөл байдалтай холбогдуулан судалгаанд оролцогчдоор төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зэргээр төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэх тогтолцоо хэрхэн бүрэлдэж буйг тодруулахыг зорив. Ингэхдээ цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож бэхжүүлэх, өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд бид дараахь шинжилгээг хийсэн болно.

Монгол Улсын төр, засгаас сүүлийн жилүүдэд төрийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр ихээхэн анхааран ажиллаж засгийн газраас ч “Цахим үндэстэн” хэмээх урт хугацааны зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Тэгвэл эл уриалга бодит байдалд хэрхэн хэрэгжиж байгааг эл судалгаагаар үр дүнг тодруулахыг зорьсон юм.

Бид судалгааны ажлын хүрээнд иргэд, олон нийтийн төрийн цахим үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээлэл ямар төвшинд байгааг болон эдгээр үйлчилгээний хүртээмжийг тандсан юм. Ингэхдээ судалгаанд оролцогчдоос дээр дурдсан төрийн цахим үйлчилгээнүүдийн чанар, хүртээмж болон эдгээр үйлчилгээний талаарх мэдээллийг тодруулж үр дүнг дараахь байдлаар танилцуулж байна (Зураг 8).

Зураг 8. Төрийн цахим үйлчилгээний мэдээлэл, оролцоо (хувь)



Дээрхээс иргэд, олон нийтийн дунд төр, засгаас сүүлийн жилүүдэд төрийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хэрхэн хандаж буйн тод жишээ бэлхнээ харагдаж буй. Судалгаанд оролцсон 468 респондентуудаар авлигын эсрэг төрийн үйлчилгээний цахим шийдлүүдийг нэвтрүүлэх нь ямар ач холбогдолтой болохыг хагас хаалттай асуултаар тодруулж, үр дүнг гаргахыг хичээв. Чингэхэд, оролцогчдоос хамгийн их ач холбогдолтой хэмээн үзсэн 3 хүртэлх хариулт сонгохыг хүссэн бидний шинжилгээний асуултад тэд дараахь хариултыг өгсөн юм. Өөрөөр хэлбэл, респондентуудын хувьд хамгийн “их ач холбогдол”-той гэж үзсэн 3 хүртэлх сонголтуудыг нэгтгэвэл судалгаанд оролцогчид нийтдээ 1559 удаагийн сонголтууд нийтлэг илэрсэн.

Хүснэгт 4. Төрийн үйлчилгээний цахим шийдлүүдийн ач холбогдол (давтамж, хувиар)

Шийдлүүд	Давтамж	Хувь
1. Төрийн үйлчилгээг шударга, шуурхай хүргэх	283	18.2
2. Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох	283	18.2
3. Төрийн үйлчилгээ авахад шаардагдах хоног хугацаа, шат дамжлагыг багасгах	227	14.6
4. Төрийн байгууллагын хүнд суртал, чирэгдлийг бууруулах	253	16.2
5. Шинэ залуу үеийн хандлагыг эергээр өөрчлөх	140	9.0
6. Иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжих	109	7.0
7. Төрийн үйлчилгээний шийдвэрлэлтийн явцад хяналт тавих	135	8.7
8. Цахимаар төлбөр, хураамжаа төлөх	122	7.8

9. Бусад	7	0.4
<b>Нийт</b>	<b>1559</b>	<b>100.0</b>

Оролцогчдын хариултын сонголтод үндэслэн авлигын эсрэг төрийн үйлчилгээний талаарх цахим шийдлүүдийн ач холбогдлыг дараахь байдлаар хоёр бүлэг болгон эрэмбэлж болох юм. *Нэгдүгээрт*, төрийн үйлчилгээг шударга, шуурхай, ил тод, нээлттэй, хүнд суртал, чирэгдэлгүй явуулах, үйлчилгээ авахад шаардагдах хугацаа, шат дамжлагыг бууруулах чиглэлээрх цахим шийдлүүдийг судалгаанд оролцогчдын 67.2 хувь нь чухал ач холбогдолтой. *Хоёрдугаарт*, шинэ залуу үеийн хандлагыг эргээр өөрчлөх, төрийн үйлчилгээний шийдвэрлэлтийн явцад хяналт, тавих, цахимаар төлбөр, хураамжаа төлөх, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжих чиглэлээрх үйл ажиллагааг нийт судалгаанд оролцогчдын 33.3 хувь нь үзсэн нь ийнхүү хоёр үндсэн бүлэгт хуваан үзэх шаардлагыг бий болгов.

Зураг 9. Төрийн үйлчилгээний цахим шийдлүүдийн ач холбогдол (хувиар)



Дээр харуулсан авлигын эсрэг төрийн үйлчилгээний талаарх цахим шийдлүүдийн ач холбогдлыг авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн сувгуудтай хэрхэн холбож, илүү үр өгөөжтэй ажиллах боломжийг үнэлэхийг эрэлхийлсэн. Ингэхдээ судалгаанд оролцогчдоос авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд мэдээллийн ямар сувгийг ашиглах нь иргэд, олон нийтэд илүү хүрэх талаар санал бодлыг нь хагас нээлттэй байдлаар 3 хүртэлх хариултыг тодруулав. Судалгаанд оролцогчдын хариулт нь давхардсан тоогоор 1434 саналд хүрч, тэдний дэвшүүлсэн саналын давтамжийг нийт хариултад эзлэх хувиар тооцон дараахь үр дүнг гарав (Хүснэгт 5). Үүнээс үзвэл, судалгаанд оролцогчдын 22 хувь нь фэйсбүүк (facebook), 18 хувь нь цахим хуудас, 13.7 хувь МҮОНТ, 13.2 хувь нь бусад телевизүүдийг ашиглах нь илүү үр дүнтэй хэмээн үзсэн.

Хүснэгт 5. Соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд мэдээллийн ямар эх сурвалжийг ашиглах талаар судалгаанд оролцогчдын санал (давтамж, хувиар)

Судалгаанд оролцогчдын санал	Давтамж	Хувь
1. Монголын үндэсний олон нийтийн телевиз	197	13.7
2. Бусад телевиз	189	13.2
3. ФМ радио	90	6.3
4. Сонин, сэтгүүл	60	4.2
5. Гарын авлага	44	3.1
6. Мэдээллийн хуудас	65	4.5
7. Зарлалын самбар	68	4.7
8. Цахим хуудас	258	18.0
9. Фэйсбүүк (facebook) хуудас	316	22.0
10. Олон нийттэй харилцах төв	129	9.0
11. Бусад (бичих)	18	1.3
<b>Нийт</b>	<b>1434</b>	<b>100.0</b>

Судалгаанд оролцогчдын 22 хувь нь фэйсбүүк (facebook), 18 хувь нь цахим хуудас, 13.7 хувь монголын үндэсний олон нийтийн телевиз, 13.2 хувь нь бусад телевизүүдийг ашиглах нь илүү үр дүнтэй хэмээн үзэж болохоор байна.

#### IV. Дүгнэлт

Эцэст нь хэлэхэд авлигын эсрэг олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, ач холбогдлыг тодорхойлох цахим хэлбэрээр зохион байгуулсан асуулгын судалгааны үр дүнд тулгуурлан дараахь хоёр хэсэгт хуваан дүгнэж болохоор байна. Үүнд:

*Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд холбогдох дүгнэлт:* Асуулгын судалгааны үр дүнгээс үзэхэд авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг судалгаанд оролцсон 3 хүн тутмын хоёр нь хэрэгцээтэй үедээ авч чаддаггүй гэж үзсэн бөгөөд түүний шалтгаан нь мэдээллийн хэрэгцээ гардаггүй, хэрэгцээтэй мэдээлэл байдаггүй гэж тайлбарлах хандлага нийтлэг байна. Мөн 20-40 хүртэлх насныхан дунд хэрэгцээтэй үедээ мэдээлэл авч чаддаггүй гэх хандлагаа 40-өөс дээш насныхантай харьцуулахад их байна. 40-өөс дээш насныханы 50-80 орчим хувь нь хэрэгцээтэй үедээ мэдээлэл авч чаддаг гэж хариулсан байна. Мөн залуучуудын авлигатай тэмцэх чиглэлийн мэдээллийг өөрт хэрэгцээгүй мэдээлэл гэж үзэх хандлага их түгээмэл байгааг анхаарах шаардлагатай.

Иргэдэд олон нийтийн сүлжээ фэйсбүүк, твиттер (*Facebook, Twitter*), телевиз, төрийн байгууллага, мэргэжилтнүүдээс голлон мэдээлэл авдаг ч, судалгаанд оролцогчдын 16.7 хувь нь авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг гол төлөв АТГ-ын фэйсбүүк (*Facebook page*), цахим хуудаснаас авдаг. Авлигын эсрэг хэрэгжүүлж буй мэдээлэл сурталчилгааны ажлуудаас ТВ нэвтрүүлэг, видео болон радио контент, гудамжны самбар, дэлгэцийн сурталчилгаа, мэдээллийн самбар, нийтлэлийн талаар түлхүү мэдэж байгаа бол өдөрлөг, нийтийг хамарсан арга хэмжээ, орон нутаг дахь сурталчилгааны талаар сайн мэдэхгүй байгаа нь

нийтлэг байна. Түүнээс гадна авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгаа дахь оролцоог хүйсээр харьцуулбал, зөвхөн мэдээлэл авах байдал эрэгтэйчүүдийн хувьд өндөр байгаа бол, мэдээлэл аваад оролцсон байдал эмэгтэйчүүдийн хувьд эрэгтэйчүүдээс өндөр хувьтай байна. Олон нийттэй харилцах үйл ажиллагааны талаар судалгаанд оролцогчид хангалтгүй хэмжээнд буйг илтгэхийн сацуу энэ чиглэлээр бодит арга хэмжээг шат дараалсан, зохион байгуулалттай хийх шаардлага бий болсон хэмээн дүгнэж байна.

*Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд холбогдох дүгнэлт:* Судалгааны хүрээнд иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй авлигын эсрэг хууль, тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах, таниулах үйл ажиллагааг судалгаанд оролцогчид дундаас доогуур үнэлсэн. Харин төрийн байгууллага хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагаас бага зэрэг өндөр байгаа нь авлигын эсрэг сургалт, семинар зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, судалгаа үнэлгээ хийх үйл ажиллагааг эрчимжүүлэх, байгууллага бүрд нийгмийн хариуцлагын хүрээнд өргөн хүртээтэй кампанит ажил өрнүүлэх, зохион байгуулах шаардлага бий болсны тод жишээ гэж болно. Иргэд, олон нийтийг хамарсан нээлттэй арга хэмжээг тогтмол үр өгөөжтэй, бүтээлч санаачилгатайгаар зохион байгуулах, цахим контент, шторк, баннер боловсруулж түгээх, тархаах үйл ажиллагааны ач холбогдлыг бодитоор үнэлж, шат дараалсан системтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий болсон. Мөн авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны нийгмийн бүлгүүд дэх хэрэгцээг тогтмол тандан судалж тэдгээрт чиглэсэн зорилтот арга хэмжээ, үйл ажиллагааг өрнүүлэх, тухайлсан хөтөлбөр, төлөвлөгөө гарган ажиллах цаг үеийн хэрэгцээ, шаардлага бий болсоор байна.

Төрийн үйлчилгээний цахим шийдлүүдийн ач холбогдлыг тогтмол үнэлж, төрийн үйлчилгээг шударга, шуурхай хүргэх, ил тод, нээлттэй болгох, төрийн байгууллагын хүнд суртал, чирэгдлийг бууруулах, төрийн үйлчилгээг авахад шаардагдах хоног хугацаа, шат дамжлагыг багасгах чиглэлээрх үйл ажиллагааны ач холбогдлыг үнэлэх, хадгалах, хянах үйл ажиллагааны цогц хөтөлбөрийг ажил хэрэг болгон мөрдүүлэх.

Иргэдийн оролцооны идэвх, санаачилгыг дэмжих, цахимаар төлбөр, хураамжаа төлөх, төрийн үйлчилгээний шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, шинэ залуу үеийн хандлагыг эергээр өөрчлөх зэрэг үйлчилгээний цахим шийдлүүдийг илүү хүртээмжтэй, цахимжилтын шинэ хандлага, арга барилыг төлөвшүүлэхэд чиглэсэн бодлого нэвтрүүлэх шаардлагатай хэмээн дүгнэж байна.

### Ашигласан материал

- UN. Signature and Ratification Status,. 2023. 9 10. Accessed September 10, 2023. <https://www.unodc.org/unodc/en/corruption/ratification-status.html> -ээс дэлгэрүүлэн үзнэ үү.
- УИХ. Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон батлах тухай. 2005. УИХ. 9 10. Accessed October 2022. <https://www.legalinfo.mn/law/details/10269?lawid=10269>.
- ЕАБХАБ, Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, 2016. *Авлигатай тэмцэх гарын авлага*. орч. «Орчуулга24» орчуулгын товчоо. Урангар пресс ХХК. Уб., Монгол Улс.
- Поуп Жереми. 2003. *Авлигалын эсрэг сурвалж бичиг*. ред. Трансперэнси интернэшнл. Уб, Монгол Улс: «Тоонот принт» ХХК.
- Transparency International. 2023. 9 10. <https://www.transparency.org/en/news/cpi-2020-asia-pacific>.
- Хатанболд О. 2010. *Монголын засаглалын үзүүлэлтүүд*. ред. Очирсүх Я. Цэцэнбилэг Ц. Уб, Монгол Улс: МХЗ9 төсөл. ФСЭХ. НҮБХХ., Сансудай ХХК.
- Transparency International. 2023. 9 9. <https://www.transparency.org/en/cpi/2021/index/mng>.
- Монгол Улсын Засгийн газар. 2021. ЗГХЭГ. 7 22. Accessed 7 22, 2021. <https://zasag.mn/news/view/25989>.
- Бадамгарав Б. (нийтлэлч). 2021. *Нямбаатар Х. Төрийн албаны хүнд суртал, авлига шан харамж нэхсэн тухай мэдээллийг 11-11 Түвэд байнга авна*. 7 20. Accessed 7 2021. <https://ikon.mn/n/2a32>.
- УИХ, АТГ. 2016. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр. *Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтын 2.1.1 дэх заалт*. УИХ.

**Санхүүжилт:** Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийг гүйцэтгэхэд тусгайлсан санхүүжилт гараагүй болно. Бид энэхүү өгүүллийг тэрлэхдээ 2022 онд АТГ-ын захиалгаар гүйцэтгэсэн гэрээт ажлын үр дүнд шинжилгээ боловсруулалтыг дахин хийж ийнхүү толилуулж буй болно.

**Талархал:** Судалгаанд цахимаар хамрагдсан олон нийт, болон өгүүллийг ийнхүү хэвлэгдэхэд бүх талын үнэтэй зөвлөгөө өгсөн сэтгүүлийн редакцын зөвлөлд талархаж буйгаа илэрхийлье.